



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/Б25

Чингис хот

Аймгийн "Хүндэт тэмдэг" болон
"Хан Хэнтийн алдартан" тэмдгүүдийг хийлгэх
зардалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, аймгийн Засаг даргын 2003 оны А/99, 2015 оны А/511 тоот захирамж, Сангийн сайдын 2018 оны 318 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймаг нийслэлийн Засаг даргаас олгох шагналын нийтлэг тодорхойлолт"-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий нутгийн хөгжлийн төлөө онцгой амжилт гаргасан иргэдийг шагнах аймгийн "Хүндэт тэмдэг" болон "Хан Хэнтийн алдартан" тэмдгүүдийг хийлгэх зардалд 5.920.000 /таван сая есөн зуун хорин мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

07 Аймгийн Засаг даргын 2020 оны
дугаар сарын 24 өдрийн 7/325
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт
1	Хан Хэнтийн алдартан тэмдэг	ш	200	12.300	2.460.000
2	Хэнтий аймгийн хүндэт тэмдэг	Ш	200	12.300	2.460.00
3	Үнэмлэх /Алдартан тэмдэг/	Ш	200	2500	500.000
4	Үнэмлэх /Хүндэт тэмдэг/	ш	200	2500	500.000
Нийт үнэ					5.920.000